



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2026 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/136

Есенбулаг сум

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1.2 дахь заалт, 50.4, 50.5 дахь хэсгүүд, Сангийн сайдын 2025 оны 05 дугаар сарын 26-ны өдрийн "Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам" А/100 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны "Аймгийн 2026 оны төсөв батлах тухай" 64 дүгээр тогтоолыг тус тус ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн орон нутгийн төсвөөс санхүүжигдэх "Санхүү хөрөнгө оруулалтын менежментийн судалгааны ажил"-ын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга: Л.Хаш-Эрдэнэ (аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)

Гишүүд:

3.Жаргалтуяа (аймгийн Засаг даргын Тамгын газрын Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалт, бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)

Б.Доржпалам (Хөндлөнгийн төлөөлөл)  
(тохиролцсон)

Ж.Мөнхцэцэг (Иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл) (тохиролцсон)

Нарийн бичгийн дарга:

Н.Цэвэлмаа (Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан батлуулж, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу шуурхай зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Үнэлгээний хороо (Л.Хаш-Эрдэнэ)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Г.ЧИНБАТ



